

**ДАРХАН СУМЫН 12-Р СУРГУУЛИЙН ҮДИЙН
ЦАЙНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ**

Төслийн нэр: Үдийн цайны хүүхдийн хоолны материал нийлүүлэх

Төслийн дугаар: ДУАЭЦС/202012014

**Харьцуулалт/ гэрээний
дугаар:**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[12-Р СУРГУУЛЬ] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Үдийн цайны хүүхдийн хоолны хүнсний материал]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020-01-23 10:00]**-аас өмнө **[Дархан-уул аймаг дархан сум 12-р сургууль (Эмчийн өрөө, М.Алтантуяа,101 тоот, Утас: 99374379)]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020-01-23]**-ны өдрийн **[10:30]**¹-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.²/Тийм/

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Дархан-уул аймаг дархан сум 7-р баг 12-р сургууль өөрийн байр (Эмчийн өрөө, М.Алтантуяа, Утас: 99374379)]

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

² Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
<ul style="list-style-type: none">(а) Үнийн санал;(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: <i>Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р сургууль</i>
ТООЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <i>Хоол хүнс нийлүүлэх ДУАЭЦС/202012014</i>
ТООЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>1-р багц Үдийн цайны хүүхдийн хоолны материал-18,200,000</i>
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Улсын төсвийн урсгал зардал: 18,200,000</i>
	Б. Тендерийн баримт бичиг
ТООЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>[Дархан-уул аймаг дархан сум 7-р баг 12-р сургууль өөрийн байр (Эмчийн өрөө, М.Алтантуяа, Утас: 99374379)]</i>
ТООЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын <i>[5] хоногоос багагүй байна.</i> Тодруулгын хариуг цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn -д байрлуулна. Тендерт оролцогч тодруулгыг цахим систем ашиглан шалгах үүрэгтэй.
	В. Тендер бэлтгэх
ТООЗ 11.1	Тендерийн хэл нь Монгол хэл байна.
ТООЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none">1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагаа эрхлэх чиглэл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулах заалт байх2. Оролцогч компаний танилцуулга3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /эх хувь/ тендер зарласнаас тендер хүлээн авах хүртэлх хугацаагаар авсан байна.4. Татварын өргүйг гэрчилсэн татварын хэлтсийн тодорхойлолт5. Хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар өөрийн харилцагч банкны тодорхойлолтыг харилцагч банк тус бүрээс авч ирүүлэх.6. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл, гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн тэмдэглэл, гэрээний үүргээ

	<p>биелүүлсэн талаар өмнөх захиалагчийн үнэлгээ, тодорхойлолт ирүүлэх, жилийн тоо: 2018,2019 он</p> <ol style="list-style-type: none">7. Нийлүүлэх барааны үнийн санал, бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.8. Тендерт гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл ирүүлэх9. Хүнсний бүтээгдэхүүний агуулах өөрийнх бол нотолсон бичиг баримт, түрээснийх бол 2019 оны түрээсний гэрээний хуулбар ирүүлнэ.
--	--

ТООЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг <i>“зөвшөөрөхгүй”</i>
ТООЗ 15.5	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: <i>[хэвлэгдсэн оныг нь оруул. Жишээ нь: “Incoterms 2000”]</i> .
ТООЗ 15.9 (б) (1) and (в) (3)	Бараа хүргэгдэх газар: <i>Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р сургууль</i>
ТООЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)	“Бараа хүргэгдэх эцсийн цэг : <i>Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р сургууль хүнсний агуулах</i>
ТООЗ 15.9 (б) (1)	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТООЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан СІР үнээс гадна дараах үнээр санал болгож болно. Үүнд: <i>[СІР –ээс бусад олон улсын худалдааны/инкотермс/ тохирох нөхцөлийг оруул]</i>
ТООЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <i>“тохируулахгүй тогтмол байна.”</i>
ТООЗ 16.1	Тендерийн валют: <i>Төгрөг байна.</i>
ТООЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: Шаардлагатай
ТООЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил . Санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерт оролцогчдын 2018, 2019 оны санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг цахим систем ашиглан шалгана. Санхүүгийн тайлан цахим системд шивэгдэж баталгаажуулахгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
ТООЗ 18.1 (г)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2 жил буюу 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлэлтийн өртгийн дундаж хэмжээ нь санал болгож буй багцын төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.
ТООЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <i>“шаардлагатай”</i> . Техникийн тодорхойлолтод заасан чанар стандартын шаардлага хангаагүй барааг шинэ бараагаар солих үүрэг хүлээнэ.

ТООЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого санал болгож үнийн дүнгийн 100 хувиас багагүй байх</i>
ТООЗ 18.2 (б)	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жилийн хугацаанд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагатай байх
ТООЗ 18.2 (в)	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <i>шаардлагагүй</i>
ТООЗ 18.2 (г)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <i>Харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, эсхүл түүнтэй тэнцэх зээлжих баталгаа нь санал болгож буй багцын үнийн 30 хувиас багагүй байна.</i>
ТООЗ 18.2 (д)	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <i>2 жил</i>
ТООЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <i>“тооцно ”</i> Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын болон орон нутгийн гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамт ирүүлэх үүрэгтэй.
ТООЗ 19.1.(б)	
ТООЗ 20.1	Тендер нээснээс хойш 5 хоногийн туршид хүчинтэй байна.
ТООЗ 21.1	Тендерийн баталгааны үнийн дүн: Санал болгож буй үнийн дүнгийн Багц 1- Мах, сүү, жимс жимсгэнэ 1% (182,000) Хүчинтэй байх хугацаа: 2020 он 01 дугаар сарын 23-ны өдрийг дуустал Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна. Тендерийн баталгааг цахимаар ирүүлээгүй нь энэ тендерээс татгалзах үндэслэл болно.
ТООЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: Цахимаар
	Г. Тендер ирүүлэх
ТООЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Байшин, гудамжны нэр: <i>7-р баг 017-р гудамж</i> Давхар болон өрөөний дугаар: <i>12-р сургууль 1 давхарт эмчийн өрөө 101 тоот</i> Аймаг, хот: <i>:Дархан-Уул аймаг, Дархан сум</i> Улс: <i>“Монгол Улс”</i> Уг тендер нь “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-аар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь “Цахим худалдан авах

	ажиллагааны систем/ www.tender.gov.mn/ -д өөрийн аж ахуй нэжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.
--	---

ТООЗ 23.3 (в)	Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон /Adobe PDF/ хэлбэрт шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.
ТООЗ 24.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: Тендерийг 2020 оны 01 дугаар сарын 23-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТООЗ 28.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: 7 дугаар баг, 017-н гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 12-р сургууль 2 давхарт санхүүгийн өрөө Дархан-Уул аймаг, Дархан сум,</p> <p>Улс: Монгол Улс</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020оны 01 дугаар сарын 23-ний өдрийн 10 цагт 30¹-т нээнэ.</p>
	Е. Гэрээ байгуулах эрх олгох
ТООЗ 40.1	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: 10</p> <p>Хүүхдийн тоо буурсан нөхцөлд захиалгын тоог дээрхи хэмжээгээр буурах болно.</p> <p>Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: 5</p>

ДАРХАН СУМЫН 12-Р СУРГУУЛИЙН ҮДИЙН ЦАЙНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНС, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Зорилго: Ерөнхий боловсролын байгууллагуудыг эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан чанартай бараа, бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахын тулд нийлүүлэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахад оршино.

Барааны тодорхойлолт: Бүтээгдэхүүн нь Монгол Улсын “Хүнсний тухай хууль”, “Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн заалтыг хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх.

Монгол улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах, шаардлагатай хүнсийг үйлдвэрлэгч эсхүл албан ёсны гэрээт борлуулагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан нийлүүлнэ.

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, дагалдах шинжилгээний бичгүүдийг нийлүүлэлт тухай бүрд тогтмол өгч байх шаардлагатай.

Ангилал	Бүтээгдэхүүний төрөл	Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага
Багц-1 Үдийн цайны хоол хүнсний материал	<i>Үхрийн мах</i>	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцсэн, гарал үүслийн гэрчилгээ бүхий 1дүгээр зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу, хэлбэр алдагдаагүй мах байна. Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолд MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна 2. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл мал, амьтнаас бэлтгэсэн байна. 3. Мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний бичигтэй байна. 4. Загсаасан буюу сэrvээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна. 5. Гулууз болон өрөөл мах нь хэвлийн цагаан шугамын дагуу тэгш ярагдсан, улаан хоолой, мөгөөрсөн хоолойг бүрэн салгасан, дотор өөхний үлдэгдэлгүй, нөжирч хурсан цус, сэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна. 6. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. 7. Тээврийн хэргэсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй байх ба тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байна. 8. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө. 9. Бүтээгдэхүүнийг ажлын 7 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хангахуйцаар 10. Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй байх.

	<p><i>Шингэн сүү</i></p> <p><i>Тараг</i></p> <p><i>Масло</i></p> <p><i>Аарц</i></p> <p><i>Эззгий</i></p>	<ol style="list-style-type: none"> 1. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC 1:2003 стандартын шаардлага хангасан эрүүл ахуйн тохиромжтой нөхцөлд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна. 2. Сүү нь түүхий сүүний техникийн шаардлага MNS 4228:2003 стандартыг хангасан байна. 3. Түүхий сүү нь малын дэлэнгийн үрэвсэл, сүрьеэ, бруцеллөз зэрэг хүнд халдварлах өвчин болон малын гоц халдварт өвчнөөр өвчлөөгүй эрүүл, тайван бүсээс бэлтгэсэн байна. 4. Итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн сүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээний бичиг, мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээтэй байна. 5. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь “MNS 5547:2005 Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав, баглаа, боодол. Техникийн ерөнхий шаардлага”, “MNS 5684:2006 Сав баглаа боодлын материалд агуулагдах хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартуудын шаардлага болон эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийг хангасан зориулалтын материалаар хийгдсэн, олон улсын стандартын тэмдэглэгээтэй сав, баглаа, боодолтой байна. 6. Хүнсний нэмэлт будаг, үнэр, амт оруулагч бодис, хувиргасан амьд организмаас гаргасан бүрдлүүдийг агуулаагүй байна. 7. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. 8. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө. 9. Тээврийн хэрэгсэл нь гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, хөргүүртэй байх ба тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн байна. 10. Бүтээгдэхүүний хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно. 11. Сүү, сүүн бүтээгдэхүүн нь хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC 1:2003 стандартын шаардлага хангасан эрүүл ахуйн тохиромжтой нөхцөлд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна. 12. Нийлүүлэгдэх тараг нь эсэг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 , бяслаг, аарц, ааруул нь уураглаг цагаан идээ техникийн шаардлага MNS 4230:2003 стандартууд болон эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байна. 13. Үйлдвэрийн болон уламжлалт аргаар бэлтгэсэн, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна. 14. Хэт исгэлэн гашуун, ахарсан амтгүй, хөгцгүй байна. 15. Цагаан өнгөтэй, шинэлэг байдлаа хадгалсан, нэгэн жигд бие бүтэцтэй, тослог зохих түвшинд байна. 16. Бүтээгдэхүүн хэрэглэх заавар, зөвлөмж зэрэг нэмэлт мэдээллийг дагалдуулж болно. 17. Бүтээгдэхүүнийг ажлын 2 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ. 18. Эрүүл, ахуй, ариун цэврийн стандарт шаардлага хангасан, экологийн, монгол уламжлалт аргаар боловсруулсан, 19. Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй байх.
--	--	---

<i>Аньс, нэрс, Чацаргана</i>	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн ,технологийн шаардлага хангасан гадаад байдал амт ба үнэр боловсролт зэргийн баримталсан байна, Аньстай дүйцэхүйц витаминлаг чанартай Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй байх.
<i>Хатаасан жимс /бүх төрлийн/</i>	Эрүүл ахуй, ариун цэврийн стандарт шаардлага хангасан, зөв аргаар хатаасан Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй байх.
<i>Зөгийн бал</i>	Сайн чанарын, эрүүл ахуй, ариун цэврийн стандарт, шаардлагад нийцсэн, цэвэр байгаль экологийн, элсэн чихрээр өтгөрүүлээгүй, үйлдвэрийн аргаар боловсруулсан Газар шимтэй дүйцэхүйц байна. Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй байх.

Боловсруулсан:

Нярав /Б.Энхжаргал/
Тогооч /О.Эрдэнэчимэг/

Хянасан:

Нягтлан бодогч /Б.Одсайхан/

2020 ОНЫ ҮДИЙН ЦАЙНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ ТАТАН АВАХ ХУВИАР

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо/ш	Х/нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (ажлын талбай)	Инкотерийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	Үхрийн мах	450	Кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсан өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

2	Сүү /шингэн/	270	л	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
3	Аарц	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 5 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
4	Масло	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
5	Байцаа	360	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
6	Төмс	360	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

7	Сонгино	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
8	Лууван	180	Кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
9	Шар манжин	180	Кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
10	Хүрэн манжин	180	Кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
11	Шөлний байцаа	27	Ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

12	Далайн байцаа	26	Ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
13	Гурил/1-р гурил/	450	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
14	Гурил /Дээд/	450	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
15	Цагаан будаа	450	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
16	Шар будаа	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
17	Хөц будаа	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

18	Гурвалжин будаа	90	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
19	Хүүхдийн будаа	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
20	Геркулес/Овьёос/	180	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
21	Нарийн гоймон	108	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
22	Мушгиа гоймон/Алейка/	270	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
23	Ургамлын тос	135	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

24	Сахар	405	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
25	Давс	90	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
26	Молоко	135	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
27	Зөгийн бал	27	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
28	Байхуу цай	9	Ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
29	Цайны идээ	27	ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

30	Түргэн исгэгч	27	ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
31	Үзэм	63	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
32	Чавга	63	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
33	Чангаанз	63	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
34	Чацаргана	54	кг	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
35	Варень	135	ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

36	Өег салат	27	ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	
37	Лечо	27	ш	Дархан сумын 12-р сургууль	Гэрээ байгуулсанаас өдрөөс бүтээгдэхүүнийг ажлын 10 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.	2020.12.31	

Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө].

	БАТЛАВ: ЗАХИРАЛ	Ч.ЭРДЭНЭБИЛЭГ						
	12-Р СУРГУУЛИЙН ҮДИЙН ЦАЙНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН 2020 ОНЫ ХУДАЛДАН АВАЛТЫН ТӨСӨВ							
								/мян.төгрөг/
Багц	Барааны нэр	Х.н	Сарын хэрэглээ			Хагас жилийн хэрэглээ		
			Тоо/ш	Нэгж үнэ	Бүгд үнэ	Тоо/ш	Нэгж үнэ	Бүгд үнэ
1-р багц Үдийн цайны хүүхдийн хоолны хүнсний материал	Мах	кг	50.0	9,000	450,000	450.0	8,500	3,825,000
	Шингэн сүү	л	30.0	1,500	45,000	270.0	1,500	405,000
	Аарц	кг	20.0	3,500	70,000	180.0	3,500	630,000
	Масло	кг	20.0	5,000	100,000	180.0	5,000	900,000
	Байцаа	кг	40.0	1,300	52,000	360.0	1,300	468,000
	Төмс	кг	40.0	800	32,000	360.0	800	288,000
	Сонгино	кг	20.0	1,300	26,000	180.0	1,300	234,000
	Лууван	кг	20.0	1,000	20,000	180.0	1,000	180,000
	Манжин	кг	20.0	1,000	20,000	180.0	1,000	180,000
	Хүрэн манжин	кг	20.0	1,000	20,000	180.0	1,000	180,000
	Шөлний байцаа	ш	3.0	3,800	11,400	27.0	3,800	102,600
	Далайн байцаа	ш	3.0	2,500	7,500	26.0	2,500	65,000
	Гурил /1-р гурил/	кг	50.0	1,200	60,000	450.0	1,200	540,000
	Гурил /Дээд/		50.0	1,600	80,000	450.0	1,600	720,000
	Цагаан будаа	кг	50.0	2,500	125,000	450.0	2,500	1,125,000
	Шар будаа	кг	20.0	2,800	56,000	180.0	2,800	504,000
	Хөц будаа	кг	20.0	1,600	32,000	180.0	1,600	288,000
	Гурвалжин будаа	кг	10.0	3,000	30,000	90.0	3,000	270,000
	Хүүхдийн будаа	кг	20.0	1,600	32,000	180.0	1,600	288,000
	Геркулейс /овъёос/	ш	20.0	1,200	24,000	180.0	1,200	216,000
	Нарын гоймон /лапша/	кг	12.0	2,100	25,200	108.0	2,100	226,800
	Мушгиа гоймон/Алейка/	кг	30.0	1,500	45,000	270.0	1,500	405,000
	Ургамалын тос	ш	15.0	3,500	52,500	135.0	3,500	472,500
	Сахар	кг	45.0	2,000	90,000	405.0	2,000	810,000
	Давс	кг	10.0	1,000	10,000	90.0	1,000	90,000
	Молоко	кг	15.0	4,500	67,500	135.0	4,500	607,500
	Зөгийн бал	кг	3.0	20,000	60,000	27.0	20,000	540,000
	Баажуу цай	ш	1.0	13,000	13,000	9.0	13,000	117,000
	Цайны идээ/их тайга/	ш	3.0	3,500	10,500	27.0	3,500	94,500
	Түргэн исгэгч	ш	3.0	6,000	18,000	27.0	6,000	162,000
	Чеснок	ш	4.0	2,600	10,400	36.0	2,600	93,600
	Үзэм	кг	7.0	10,000	70,000	63.0	10,000	630,000
Хар чавга	кг	7.0	10,000	70,000	63.0	10,000	630,000	
Чангаанз	кг	7.0	10,000	70,000	63.0	10,000	630,000	
Чацаргана	кг	6.0	10,000	60,000	54.0	10,000	540,000	
Варень	ш	15.0	3,800	57,000	135.0	3,800	513,000	
Өөг салат	ш	3.0	3,500	10,500	27.0	3,500	94,500	
Лечо	ш	3.0	5,000	15,000	27.0	5,000	135,000	
Нийт дүн								18,200,000
	Судалгаа гаргасан Нярав:		Б.Энжаргал					
	Хянасан Нягтлан бодогч:		Б.Одсайхан					

1. Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө. Үүнд мөн тендерт оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно.

Хэрвээ захиалагч техникийн тодорхойлолтын хураангуйг гаргуулахаар бол дараах хүснэгтийг ашиглан шаардлагатай мэдээллийг тусгаж өгнө. Тендерт оролцогч санал болгож буй бараа, үйлчилгээ нь уг шаардлагад нийцэж байгаа эсэхийг ижил хүснэгтээр харуулна.

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

**12-Р СУРГУУЛИЙН ХООЛ ХҮНС ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ
ТУСГАЙ НӨХЦӨЛ**

<p>1.Шалгах болон турших</p>	<p>Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор сургуулийн хяналт шинжилгээ үнэлгээний баг, ахлах тогооч гэрээ байгуулахаас өмнө хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа газар болон хадгалж байгаа газар биечлэн очиж дүгнэлт гаргана. Гэрээ байгуулснаас хойш улиралд 1 удаа хяналт тавина.</p>
<p>2.Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</p>	<p>Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэх. 2) Барааг хүргэсэн тухай баримт, /АШБ/ 3) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ 4) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; барааны гарал үүслийн гэрчилгээ./бусад хяналт шалгалтын баримт/ <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p>
<p>3.Баталгаат засвар</p>	<p>Үйлдвэрлэгчийн тухайн бараан олгодог баталгаат засварын хугацааг бараан дээр заавал тависан байна. Гэмтэлтэй бараа бүтээгдэхүүнийг цаг тухайд нь сольж өгнө.</p>
<p>4.Гэрээнд өөрчлөлт оруулах</p>	<p>Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.</p>
<p>5.Төлбөр</p>	<p>Захиалагч төлбөрийн нэхэмжлэх хүлээн</p>

	<p>авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Төрийн сан банкаар шилжүүлнэ. Мөн тухайн сар, улиралд хувиарлагдсан төсвөөс хамааран нэхэмжлэлийг 100 хувь барагдуулахгүй бол нийлүүлэгч байгууллагатай тооцон нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулан тохиролцоно.</p>
6.Бараа нийлүүлэх хуваарь	<p>Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. /Бараа хадгалах зориулалтын агуулах сав муутай учир ажлын 10 хоногийн нөөцөөр татна/</p>
7.Алданги оногдуулах	<p>Ашгийн төлөө бус төсөвт байгууллага учир алданги торгууль хүлээхгүй.</p>
8.Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах	<ol style="list-style-type: none"> 1) Гэрээ техникийн тодорхойлолт, стандартад нийцээгүй чанаргүй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлсэн. 2) Торгууль алданги тооцосон 3) Цаг тухайд нь бараа бүтээгдэхүүнийг хүргэж өгөөгүй цэцэрлэгийн хүүхдийг хоол хүнсээр тасалдуулсан зэрэг тохиолдолд гэрээг цуцлах болно.
9.Маргааныг шийдвэрлэх	<p>Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p>

**ЗАХИА
ЛАГЧ**

**НИЙЛҮҮ
ЛЭГЧ**

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нуггийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛА
ГЧИЙГ
ТӨЛӨӨЛ
Ж:**

**НИЙЛҮҮ
ЛЭГЧИЙ
Г
ТӨЛӨӨЛ
Ж:**

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо¹³:2020-01-16

Тендер шалгаруулалтын нэр: Дархан сум 12-р сургууль
ДУАЭЦС/202012014

Дархан –Уул аймгийн 12-р сургуулийн эрх
бүхий тендерт оролцогчдоос **Үдийн цайны хүүхдийн хоол хүнсний
материал** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь Төрийн цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа
цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн
баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000
/**тавин мянган**/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[5]** хоногийн дотор хүчинтэй байна. Тендер нь дараах
багцаас бүрдэнэ. Үүнд:

1-р багц Үдийн цайны хоол хүнсний материал-18,200,000

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

**Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын жилийн
борлуулалтын орлого санал болгож үнийн дүнгийн 100 хувиас багагүй байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
Зээлжих баталгаа нь санал болгож буй багцын үнийн 30 хувиас багагүй байна.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил
/2018,2019 он/**

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Дундаж хэмжээ нь
санал болгож буй багцын төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.

Тусгай зөвшөөрөл : - шаардлагагүй

Тендерт оролцогчид оролцож буй багц тус бүрд тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн
баталгаа нь багцын төсөвт өртгийн үнийн дүнгийн 1 хувь байна. /Хүчинтэй хугацаа тендер нээснээс
хойш 45 хоног хүчинтэй байна/

1-р багц үдийн цайны хоол хүнсний материал-182,000

Төсөвт өртгийн 1 хувиар баталгааны хэмжээг тогтоож үнийн дүнг оруулсан болно.

Тендерийг **2020 оны 01 дугаар сарын 23-ний өдрийн 10 цаг 00** минутаас өмнө
www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан
тендерийг **2020 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дархан-Уул аймгийн 12-р сургуулийн эмчийн өрөө 101 тоот

Утас/ факс 99374379

Эмч:М.Алтантуяа